



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 21 өдөр

Дугаар 4/451

Номгон

Г Аймгийн Засаг даргын нэрэмжит санхүүгийн
нэгдсэн шалгалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйл 29.1.1 "а" Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 3.1.48 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Санхүүгийн сахилга батыг сайжруулах, төсөв санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, гарч буй зөрчил дутагдлыг арилгах, бууруулах зорилгоор Баянлиг, Жаргалант сумдад аймгийн Засаг даргын нэрэмжит санхүүгийн нэгдсэн хяналт шалгалтын ажлыг 2021 оны 07 дугаар сарын 21-нээс 08 дугаар сарын 02-ны хооронд Эрдэнэцогт, Баацагаан сумдад 2021 оны 09 дүгээр сарын 15-наас 09 дүгээр сарын 22-ны хооронд зохион байгуулсугай.

2. Нэгдсэн хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч С.Байгалмаа- Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Гишүүд Д.Даваажаргал- Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

С.Рэнцэндагва- Татварын хэлтсийн дарга

Ц.Идэрмөнх- Орон нутгийн өмчийн газрын дарга

Х.Ганзориг- Статистикийн хэлтсийн дарга

3. Уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг сумдын Засаг дарга, Санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч нарт тус тус үүрэг болгосугай.

4. Хяналт шалгалт хийх удирдамжийг хавсралтаар баталсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Энхбаяр)- д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

601210051

D:\2021\Zakhiramj-2021 on\Захирамж-2021 он.docx